

АЙМГИЙН ХҮН АМ, НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

I. ТӨСӨВ: Аймгийн төсвийн орлогод 4.0 тэрбум төгрөг орж, төлөвлөгөө 72 %-иар давсан байна.

Наран, Онгон, Эрдэнэцагаан, Баруун-Урт сумдаас бусад сумд төсвийн орлогын төлөвлөгөөгөө давж биелсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлага 2.6 тэрбум төгрөг болжээ.

II. МӨНГӨ, ЗЭЭЛ: Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас ААНБ, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 24.1 тэрбум төгрөгт хүрч, 2010 оны жилийн эцсээс 4.6 тэрбум төгрөгөөр буюу 23.3 %-иар өсчээ.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 15.6 тэрбум төгрөг болж, 2010 оны жилийн эцсээс 4.2 тэрбум төгрөгөөр буюу 36.6 хувиар өссөн байна.

III. ХӨДӨӨ АЖ АХУЙ: Малын төллөлт, онд оролт: Оны эхний төллөх эх малын 78.0 хувь болох 669.4 мянган эх мал төллөж, гарсан төлийн 99.3 хувь болох 669.3 мянган төл бойжиж байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Оны эхний малын 2.0 хувь болох 39.2 мянган мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 98.0 хувьтай байна.

Асгат, Эрдэнэцагаан, Дарьганга, Наран, Онгон, Халзан, Баяндэлгэр, Түмэнцогт сумдад оны эхний малын 4.84 – 0.98 хувь болох 35.8 мянган толгой мал хорогдоод байгаа нь нийт хорогдлын 91.4 хувийг эзлэж байна.

IV. АЖ ҮЙЛДВЭР: Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2005 оны зэрэгцүүлэх үнээр 11.7 тэрбум төгрөг болж, борлуулалт 46.8 тэрбум төгрөгт хүрсэн нь урьд оны мөн үеэс доогуур гүйцэтгэлтэй байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн болон борлуулалт буурсан нь Андын илч, Галын гал, Эрдэнийн олз, ХХК-нууд үйлдвэрлэлт эрхлээгүйтэй холбоотой байна.

Гол нэр төрлөөс талх, хиам, нүүрс, дулаан үйлдвэрлэлт, замын хавтан, боржуур нэмэгдсэн.

V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС: 5-р сард Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын ерөнхий индекс өнгөрсөн оны 12 сарынхаас 6.5 хувиар өссөн байна.

Энэ өсөлтөнд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 13.1 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодисны бүлгийн үнэ 1.0 хувиар, хувцас, бөс бараа, гуталны бүлгийн үнэ 1.3 хувиар, орон сууц, ус цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ тариф 0.4 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 5.1 хувиар, тээврийн бүлгийн үнэ тариф 0.9 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ. Харин эм тариа эмнэлгийн үйлчилгээ, холбоо, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ, зочид буудал нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний бүлгийн үнэ тариф тогтвортой байна. Өнгөрсөн сараас үнэ тарифын ерөнхий индекс 4.1 хувиар өссөн байна.

VI. ЭРҮҮЛ МЭНД: 544 эх амаржиж, 546 хүүхэд төрсөн нь урьд оны мөн үеэс дээгүүр байна.

Халдварт өвчнөөр 238 хүн өвчилсөн нь урьд оны мөн үеэс 3-аар олон байгаа бөгөөд мөөгөнцөр, салхицэцэг, трихоминиаз, заг зэрэг өвчлөлтүүд өссөн байна.

VII. АЖИЛГҮЙЧҮҮД: ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 1164 болж, эхний 5 сард 257-аар нэмэгдсэн байна. Ажилгүй иргэдийг насны ангиллаар нь үзвэл 79.5 хувь нь 16-34 насны залуучууд байна. Боловсролын түвшинээр авч үзвэл 21.1 хувь нь дээд, 2.5 хувь нь тусгай дунд, 34.5 хувь нь бүрэн дунд, 8.1 хувь нь мэргэжлийн анхан шатны боловсролтой хүмүүс байна.

Эхний 5 сард 1175 хүн шинээр бүртгүүлж, 902 хүн ажилд орсны дотор шинэ ажлын байранд 378 хүн ажиллаж байна.

VIII. ГЭМТ ХЭРЭГ: Бүртгэгдсэн гэмт хэрэг 96 байгаа нь урьд оны мөн үеэс дээгүүр байна. Гэмт хэргийн улмаас 21 хүн нас барж, 23 хүн гэмтэж осолдсон нь урьд оны мөн үеэс өссөн байна. ААНБ, иргэдэд 14.1 сая төгрөгийн хохирол учирсны 12.1 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 102 хүн сэжиглэгдсэний 17.6 хувь нь согтуугаар хэрэг үйлджээ. Нийт 1239 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеэс 166 хүнээр олон байгаа бөгөөд баривчлуулсан хүний тоо урьд оны мөн үеэс дээгүүр байна.

АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС